

ISO 14001 Стандарт Танилцуулга

ISO гэж юу вэ?

ISO буюу Олон улсын стандартчиллын байгууллага (Франц хэлээр *Organisation Internationale de Normalization* бөгөөд ISO хэмээн товчлон бичдэг) нь олон улсын стандартуудыг тогтоодог хамгийн том байгууллага юм. ISO стандартууд нь хамгийн өргөн хэрэглэдэг, зах зээлд нийцэхүйц, сайн дурын стандарт болон гэрчилгээжүүлэлтийн систем юм. ISO нь голдуу тодорхой нэгэн бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процессд хэрэглэх техникийн стандартуудыг тухайн бараа болон үйл явцыг илүү өндөр үр бүтээмжтэй, аюулгүй, байгал орчинд хор хохиролгүй үйлдвэрлэх зорилгоор боловсруулдаг. Хэдийгээр ISO нь хууль ёсны байгууллага биш, стандартуудыг зөвхөн сайн дурын үндсэн дээр боловсруулан гаргадаг боловч олон орны засгийн газрууд өөрсдийн зохицуулалтын хэрэгсэл болгон ашиглах зорилгоор хүлээн зөвшөөрсөн байдаг. ISO нь ТББ-ууд болон судалгааны хүрээлэнгүүдийн бүхэл сүлжээ бөгөөд үүний нарийн бичгийн дарга нарын газар нь Женев хотод байрладаг.

ISO 14001 гэж юу вэ?

ISO 14000 нь удирдлагын систем болон байгал орчны талаарх стандартуудын цогц бөгөөд ямар нэгэн тодорхой бараа, бүтээгдэхүүнийг онцлон заадаггүйгээрээ ISO-ийн бусад стандартуудаас ялгардаг. 14001 стандарт нь Байгал орчны удирдлагын системд хамаардаг. Монгол улсын хуулиар уул уурхайн үйл ажиллагаа эрхлэж буй компаниуд өөрийн Байгаль орчны удирдлагын системтэй байхыг шаарддаг.

ISO 14001 нь олон улсын шилдэг практикт нийцэх эсэхийг баталгаажуулах зорилгоор Байгал орчны удирдлагын системд зайлшгүй шаардагдах бодлого болон үйл явцыг тодорхойлдог. Стандартууд нь Байгал орчны удирдлагын системийн олон талыг хамардаг бөгөөд үүнд мониторинг болон арга хэмжээ, үйл ажиллагааны хяналт, хууль зүйн шаардлагууд, онцгой нөхцлийн бэлэн байдал, баримт бичгийн хяналт, байгал орчны тэмдэглэл, харилцаа холбоо болон сургалт зэргийг багтаадаг. ISO 14001 нь Байгал орчны удирдлагын системд зориулан хувийн болон олон нийтийн байгууллагуудаас жижиг бизнес эрхлэгчид болон үндэстэн дамнасан байгууллагуудын оролцоотойгоор зохиогдсон. 14001 стандартын бүтэц нь энэхүү стандартад нийцэж байгаа эсэхээ компаниуд гуравдагч талаар баталгаажуулах нөхцлийг хангах зорилгоор хийгдсэн. 14001 стандартыг хангасан талаараа гэрчилгээжүүлэлтэд хамрагдах нь сайн дурын боловч олон тооны компаниуд гэрчилгээжүүлэлтэд хамрагдахыг эрхэмлэдэг.

ISO 14000 цогц стандарт

- Байгал орчны удирдлагын системийг хэрэгжүүлэх нь: 14001, 14002, 14004
- Байгал орчны аудит 19011 (14010, 10411, 14012, 14015 стандартуудыг орлон боловсруулсан)
- Байгал орчны гүйцэтгэлийн үнэлгээ: 14031, 14032, 14050
- Байгал орчны хаягжуулалт: 14020, 14021, 14024, 14025
- Амьдралын мөчлөгийн үнэлгээ: 14040, 14041, 14042, 14043, 14047, 14048, 14049
- Байгал орчны удирдлага, мэдээлэл харилцаа болон тайлагналт: 14063, 14064

ISO 14001 ийн гэрчилгээжүүлэлт хэрхэн явагддаг вэ?

Компаниуд ISO 14001 стандартыг даган мөрдөж байгаагаа бие даасан гуравдагч талын аудиторуудтай гэрээ байгуулан, тэднээр хийлгэн баталгаажуулдаг. ISO нь өөрөө гэрчилгээжүүлэх болон гэрчилгээ олгох үйл ажиллагааг эрхлэдэггүй. Монголын хөрш орнуудад гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалтын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа ч одоогоор Монгол улсад хараахан үйл ажиллагаагаа эхлээгүй байна. Гэрчилгээжүүлэлтийн байгууллага нь ISO аас гаргасан дүрэм, журмыг даган мөрдөж байгаа талаарх гэрчилгээг олгодог бол харин баталгаажуулалтын байгууллага нь ISO стандартуудын дагуу гэрчилгээжүүлэх эрхийг олгодог байгууллага юм. Гэрчилгээжүүлэлт болон баталгаажуулалтын

байгууллагууд нь ISO аас гаргасан тусгай дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг боловч ISO- аас хараат бус байдаг. 2001-2005 онуудад, 111,162 ширхэг ISO 14001 гэрчилгээг 138 улсад олгоод байна. 2005 оны байдлаар ISO 14001 гэрчилгээ Монгол улсад олгогдоогүй байна.

Эх үүсвэрүүд

ISO 14000 болон бусад 9000 стандартыг агуулсан веб хуудас	www.iso.org/iso/en/iso9000-14000/index.html
14000 стандартыг хариуцсан Техникийн хороо	www.tc207.org
ISO- ийн баталгаажуулах болон гэрчилгээжүүлэх агентлагууд	www.iso.org/iso/en/info/ISODirectory/intro.html